

МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ХИЛИЙН БООМТ “ЧИНГИС ХААН” ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН ГАДНА ТАЛБАЙД ТӨРИЙН ДАЛБАА БАЙРШУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

1. Төслийн нэр: Монгол Улсын агаарын хилийн боомт “Чингис хаан” олон улсын нисэх буудлын гадна талбайд Төрийн далбаа байршуулах
2. Төсөл боловсруулах үндэслэл: “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХТ-24/04 тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
3. Байршил: Төв аймаг. Сэргэлэн сум. “Чингис хаан” ОУНБ.
4. Захиалагч: “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК
5. Ерөнхий үзүүлэлт: Төрийн далбааны шон, суурь нь Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангасан, цаг уурын -50+50°C температурт болон тухайн орчны салхины ачаалал дааж ажиллах чадвартай байх.
6. Ажлын бүрэлдэхүүн:
 - 6.1. Дизайн болон ажлын зураг боловсруулах
 - Төрийн далбаан зай хэмжээний төлөвлөлт, дизайн нь ЧХОУНБ-ын ерөнхий концепц, дизайнтай нийцсэн байх,
 - Далбаан шон, тоноглолын угсралтын зураг,
 - Төрийн далбааны шон, суурь, орчны тохижилтын хэмжээний зохицлын 3D зураг,
 - Гадна тохижилт, ногоон байгууламжийн ландшафт төлөвлөлт,
 - Төмөрбетон суурийн ажлын зураг,
 - Цахилгааны тэжээл нь техникийн нөхцлийн дагуу олгогдсон цахилгаан хуваарилах щитнээс газар доогуур кабелиар тэжээгдэх ба зай хэмжээг ажлын зургийн явцад тодруулах,
 - Өндрийн саадын болон орчны гэрэлтүүлгийн дизайн, ажлын зураг,
 - 6.2. Далбаан шон, тоноглолын техникийн шаардлага
 - Төрийн далбааны шон, тоноглол 2024 онд үйлдвэрлэгдсэн байх,
 - Далбааны шонгийн өндөр 25 метр,
 - Шонгийн хийц ган төмөр хоолой,
 - Цахилгаан мотор бүхий далбаа өргөгчтэй байх
 - Далбаан болон орчны гэрэлтүүлэгтэй /үндсэн болон нарны тэжээл/ байх,
 - Нисэхийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан Өндрийн саадын анивчдаг улаан гэрэлтэй байх
 - 6.3. Суурь, тохижилтын ажил
 - Төрийн далбааны суурь нь төмөрбетон хийцтэй байх,
 - Үйлдвэрлэгчийн техникийн шаардлагыг бүрэн хангасан байх, /ажлын зургийг гүйцэтгэгч байгууллага хийнэ/,
 - Суурийн гадна тал нь гантиг, байгалийн чулуу, түүнтэй дүйцэхүйц материал байх,
 - Дизайн зургийн дагуу орчны талбайг тохижуулах, зүлэгжүүлэх,
 - Талбайн гэрэлтүүлэг,
 - Машин зогсоолоос далбааны суурь хүртэлх явган хүний зам зургийн дагуу,
 - Цахилгааны холболт
7. Бусад тавигдах шаардлага:
 - Гүйцэтгэгч нь тугны байршил, дизайн, инженерингийн хийцлэл, шийдлүүдийг эскизийн шатанд захиалагч ХХНОБ ТӨХХК, Хилийн боомтын болон “Чингис хаан” ОУНБ-ын үйлчилгээ эрхлэгч нарт танилцуулан зөвшилцөх,
 - Гүйцэтгэгч байгууллага нь энэхүү ажлын даалгаврын дагуу зураг төсөл боловсруулах зөвлөхийн болон барилга угсралтын тусгай зөвшөөрөл бүхий сонгон шалгаруулалтаар шалгарсан мэргэжлийн хуулийн этгээд байна,
 - Шон, тоноглолын ашиглалтын гарын авлага, 11 ширхэг даавуун /10м x 5м шонгийн өндөртэй зохистой харьцаатай байх/ далбаа.
8. Баталгаат хугацаа: Ашиглалтад хүлээлгэн өгч, гэрээ дүгнэсэн өдрөөс хойш 2 жилээс доошгүй байх,

9. Төсөл гүйцэтгэх хугацаа: 2024 оны 6-7 сар.
Ажил гүйцэтгэх урьдчилан сонгосон газрын байршлийн зургийг хавсаргав.